

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/53/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 260949 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Наранбат Утас: 261628 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ниямазон аудит ХХК-ийн захирал З.Цээнээ Утас: 70145906 Цахим хаяг: audit@nmz.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ
КЛИРИНГИЙН ТӨВ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ О.ЭРДЭНЭГЭРЭЛ ТАНАА

2024.03.15

№

04/679

танай

-ны №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байсан “Солар сис” програмыг ашиглалтаас хасч, Гүйцэтгэх захирлын 2023 оны А/12 дугаар тушаалаар санхүү, нягтлан бодох бүртгэлийн “Смарт эккаунтинг” програмыг ашиглаж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 07 дугаар тогтоолоор баталсан 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 9 дүгээр сарын 23 дугаар тогтоолоор нэмэгдүүлэн тодотгож, нийт орлогыг 866.7 сая төгрөг, нийт зардлыг 840.1 сая төгрөг, татварын өмнөх ашгийг 26.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,966.3 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Гүйцэтгэлээр нийт 691.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 687.9 сая төгрөгийн зардал гарган, 3.2 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,300,564,167.60	5,538,695,029.20
1.1.2	Дансны авлага	45,229,970.91	75,041,780.81
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	5,256,971.68	7,073,039.74
1.1.4	Бусад авлага	5,032,348.09	9,172,473.08
1.1.6	Бараа материал	4,961,681.00	5,141,821.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,778,788.31	14,925,433.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,369,823,927.59	5,650,049,577.46
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	100,814,376.80	176,671,678.09
1.2.2	Биет бус хөрөнгө	96,935,064.54	84,584,855.13
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	9,026,335.73	9,026,335.73
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	206,775,777.07	270,282,868.95
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,576,599,704.66	5,920,332,446.41
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	12,853,235.06	-
2.1.1.3	Татварын өр	-	9,917,038.76
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,893,238.51	-
2.1.1.12	Бусад богино хугацаат өрт төлбөр	1,372,907,191.70	2,733,010,265.89
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,388,653,665.27	2,742,927,304.65
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	10,252,858.90	10,252,858.90
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	10,252,858.90	10,252,858.90
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,398,906,524.17	2,753,180,163.55
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: төрийн	2,000,000,020.75	2,000,000,020.75
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	23,781,409.08	23,781,409.08
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	470,797,343.22	470,797,343.22
2.3.9	Хуримтлагдсан ашиг	683,114,407.44	672,573,509.81
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,177,693,180.49	3,167,152,282.86
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,576,599,704.66	5,920,332,446.41

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	470,289,682.13	513,451,526.18
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	470,289,682.13	513,451,526.18
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	115,587,236.08	175,001,937.59
6	Бусад орлого	200,000.00	2,620,007.04
7	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
8	Ерөнхий ба удирдлагын зардал	542,080,620.68	687,724,079.55
9	Санхүүгийн зардал	-	-
10	Бусад зардал	-	-
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	793,510.42	(155,461.49)
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
13	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	44,789,807.95	3,193,929.77
14	Орлогын татварын зардал	11,558,723.61	17,500,193.76
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	33,231,084.34	(14,306,263.99)

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 01 сарын 01-ны үлдэгдэл	2,000,000,020.75	7,160,000.00	-	1,259,416,984.55	3,266,577,005.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	2,763,681.77	2,763,681.77
3	Залруулсан үлдэгдэл	2,000,000,020.75	7,160,000.00		1,262,180,666.32	3,269,340,687.07
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	33,231,084.34	33,231,084.34
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	470,797,343.22	(470,797,343.22)	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	(141,500,000.00)	(141,500,000.00)
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	16,621,409.08	-	-	16,621,409.08
8	2022 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	2,000,000,020.75	23,781,409.08	470,797,343.22	683,114,407.44	3,177,693,180.49
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	3,765,366.36	3,765,366.36
10	Залруулсан үлдэгдэл	2,000,000,020.75	23,781,409.08	470,797,343.22	686,879,773.80	3,181,458,546.85
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(14,306,263.99)	(14,306,263.99)
12	2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	2,000,000,020.75	23,781,409.08	470,797,343.22	672,573,509.81	3,167,152,282.86

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	85,431,598,351.90	82,135,001,197.64
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	465,272,091.77	494,599,409.49
	Бусад мөнгөн орлого	84,966,326,260.13	81,640,401,788.15
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	84,961,585,153.51	80,912,034,663.67
	Ажиллагчдад төлсөн	257,097,695.05	325,758,769.37
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	73,826,233.26	100,132,637.52
	Бараа материал худалдан авахад төлсөн	3,333,503.00	5,574,176.00
	Ашиглалтын зардалд төлсөн	29,224,941.32	60,719,116.03
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,336,000.00	-
	Татварын байгууллагад төлсөн	36,835,818.19	38,923,205.06
	Даатгалын төлбөрт төлсөн	500,000.00	-
	Бусад мөнгөн зарлага	84,559,430,962.69	80,380,926,759.69
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	470,013,198.39	1,222,966,533.97
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	85,699,147.18	132,367,524.96
	Хүлээн авсан хүүний орлого	85,699,147.18	132,367,524.96
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	58,779,620.00	117,195,748.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	42,539,870.00	111,035,748.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	16,239,750.00	6,160,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	26,919,527.18	15,171,776.96
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	141,500,000.00	-
	Төлсөн ногдол ашиг	141,500,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
	Валютын ханшийн зөрүү	650,083.84	(7,449.33)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	356,082,809.41	1,238,130,861.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,944,481,358.19	4,300,564,167.60
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,300,564,167.60	5,538,695,029.20

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	866,779.0	691,073.5	(175,705.5)	79.7
1.1	Клирингийн шимтгэлийн орлого	683,200.0	469,318.0	(213,882.0)	68.7
1.2	Гишүүний хураамж	24,000.0	44,000.0	20,000.0	183.3
1.3	Хүүгийн орлого	159,579.0	175,001.9	15,423.0	109.7
1.4	Банкны шимтгэл	-	133.5	133.5	-
1.5	Бусад орлого	-	2,620.0	2,620.0	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	840,135.4	687,879.5	(152,255.9)	81.9
2.1.1	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	339,949.2	307,810.5	(32,138.7)	90.5
2.1.2	Хоол унааны зардал	40,392.0	31,494.8	(8,897.2)	78.0
2.1.3	Байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэл-12.5 хувь	48,169.7	43,388.0	(4,781.7)	90.1
2.1	Цалингийн зардал	428,510.9	382,693.2	(45,817.7)	89.3
2.2.1	ТУЗ-ийн цалин	68,190.5	64,501.7	(3,688.8)	94.6
2.2.2	ТУЗ-ийн нийгмийн даатгалын шимтгэл-12.3 %	8,387.5	7,933.7	(453.8)	94.6
2.2.3	ТУЗ-ийн бусад зардал	1,210.0	904.9	(305.1)	74.8
2.2	ТУЗ-ийн зардал	77,788.0	73,340.3	(4,447.7)	94.3
2.3.1	Оффисын түрээс	58,500.0	51,791.7	(6,708.3)	88.5
2.3.2	Цахилгааны зардал	1,950.0	607.5	(1,342.5)	31.2
2.3.3	Интернэт ашиглалт	4,500.0	4,500.0	-	100.0
2.3.4	Мэдээлэл дамжуулах суваг түрээс	5,580.0	1,425.6	(4,154.4)	25.5
2.3	Ашиглалтын зардал	70,530.0	58,324.8	(12,205.2)	82.7
2.5.1	Шагнал	6,615.2	-	(6,615.2)	-
2.5.2	Тэтгэмж	4,600.0	891.0	(3,709.0)	19.4
2.5.3	Ажиллагсдын эрүүл мэндийг дэмжих зардал	800.0	648.1	(151.9)	81.0
2.5.4	Арга хэмжээний зардал	7,540.0	2,753.2	(4,786.8)	36.5
2.5	Арга хэмжээний зардал	19,555.2	4,292.3	(15,262.9)	21.9
2.6.1	Монгол банкны сүлжээний ашиглалтын зардал	4,800.0	4,800.0	-	100.0
2.6.2	Аудитын үйлчилгээний хөлс	4,400.0	4,400.0	-	100.0
2.6.3	Даатгалын төлбөр	700.0	-	(700.0)	-
2.6.4	Жижиг төлбөр хураамж татвар	1,130.0	606.0	(524.0)	53.6
2.6.5	Гүйлгээний шимтгэлийн зардал	600.0	952.5	352.5	158.8
2.6.6	Гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит алдагдал	-	155.5	155.5	-
2.6	Төлбөр хураамж, үйлчилгээний зардал	11,630.0	10,914.0	(716.0)	93.8
2.7	Бараа материал, бичиг хэрэг, аж ахуйн материал	5,044.8	4,984.7	(60.1)	98.8
2.8	Шуудан холбоо	1,605.0	1,303.2	(301.8)	81.2
2.9	Урсгал засварын зардал	1,000.0	544.5	(455.5)	54.4
2.10	Мэдээллийн үйлчилгээ, лицензийн зардал	36,784.2	14,922.0	(21,862.2)	40.6
2.11	Маркетингийн зардал	3,200.0	878.8	(2,321.3)	27.5

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.12	Сургалтын зардал	8,296.5	6,845.0	(1,451.5)	82.5
2.13	Нөөц төвийн зардал	17,928.0	7,712.8	(10,215.2)	43.0
2.14	Гадаад томилолтын зардал	19,576.3	19,540.2	(36.2)	99.8
2.15	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	68,220.0	46,015.2	(22,204.8)	67.5
2.16	Нүүлгэлтийн зардал	1,105.0	880.1	(224.9)	79.7
2.17	Элэгдлийн зардал	69,361.5	54,688.7	(14,672.8)	78.8
3	Үйл ажиллагааны ашиг	26,643.6	3,193.9	(23,449.6)	12.0
	Орлогын албан татвар	15,957.9	17,500.2	1,542.3	109.7
4	Татвар төлсний дараах ашиг	10,685.7	(14,306.3)	(24,991.9)	133.9
5	Хөрөнгө оруулалт	1,966,355.4	118,195.7	(1,848,159.7)	6.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9.9 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хувь хүний орлогын албан татварыг төлөөгүйн улмаас санхүүгийн тайланд өр төлбөр үүссэн байна.	1	9,917.0					1	9,917.0
Дүн	1	9,917.0					1	9,917.0

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 213.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Клирингийн шимтгэлийн орлогын төлөвлөгөө 31.3 хувиар тасарсан байна.	1	213,882.0			1	213,882.0		
Дүн	1	213,882.0			1	213,882.0		

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,